




ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

СБД-ийн Хоймор оффис төвийн зүүн хойд булан байгаа явган хүний зам болон хашааг Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар нь дулааны шугам холбох гээд энэ хэсгийн замыг эвдэлж сүйтгэсэн. 2024 оны 8-р сард энэ ажлаа хийсэн ч одоо болтол нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

Нийслэлийн БГД УВ паласын дэргэд шөнийн цагаар барилга барьж байна. Барилгын ажил 24 цагийн турш явагдаж, шөнийн цагаар хүнд машин механизмууд ажиллаж унтуулж амраахгүй байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

БЗД-16, 10-р байрны хүүхдийн талбайг нурааж оронд хөшөө босгосон байна. Хүүхдийн тоглоомын талбайг нурааж хөшөө барина гэдэг байж болохгүй зүйл. Уг хөшөөг буулгаж, хүүхдийн тоглоомын талбайг эргүүлэн байршуулах хэрэгтэй байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

334

أفصح ما في القرآن من المعاني والآثار

[illegible]

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ: ОНЦЛОХ ГОМДОЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

✓ **ХУД-ийн Цагдаагийн ерөнхий газрын Дэслэгч н.Баярмагнайд баярлаж талархсанаа илэрхийлж байна. Түргэн шуурхай үйлчилгээтэй зөлдөг найрсаг харилцаатай танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.**

- БЗД-13 хороонд гомдол гаргаж байна. 09 сарын 12-ны 15:00 минутад Үйлчлүүлэхэд Засаг даргын өрөө нь цоожтой нийгмийн ажилтан нь амралттай. Ажлын цагаар нэг өрөөндөө 8-9 эмэгтэй суучихсан хөзөр тоглож байна. Татвар төлөгчдийн мөнгөөр цалинжиж байгаа хүмүүс ийм бүдүүлэг байдалтай байж болохгүй. Ажлаа мэдэхгүй, ажлаа хийгүй төрийн алба ямар болчихсон юм бэ? ингэж төрийн ажил хийж болох уу? энэ хороог татан буулгаж өгнө үү. Ямар арга хэмжээ авсан талаар эргэн мэдэгдэнэ үү.

НИЙГМИЙН ДААТГАЛ

- Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст 2025 оны 07 дугаар сард ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийн материал бүрдүүлэн өгч тэтгэмж авах хуваарь маань ирсэн. Эхний тэтгэмжийн хугацаа 08 дугаар сарын 11 нд байсан боловч товлосон хугацаандаа ороогүй хоцорч орсон.Одоо энэ 9 дүгээр сарынх товлосон хугацаандаа бас л орсонгүй. Яаралтай энэ асуудлыг шийдэж тэтгэмжийг маань яаралтай оруулж өгнө үү.
- СХД-ийн Нийгмийн даатгалд гомдолтой байна. Би хүү Түвшинтөгсийн Түвшинбатын тэжээгчээ алдсаны тэтгэмжийг авдаг юм. Гэтэл дүүргийн Нийгмийн даатгалын газраас утасдаад та тэтгэврээ илүү тогтоолгосон байна илүү мөнгө идсэн байна гээд тэтгэврийг зогсоочихлоо. 827,000 төгрөгийн тэтгэврийг 570,000 төгрөг болгож бууруулчихаад бууруулснаа ч өгөхгүй, миний хүүхдийн тэжээгчээ алдсан тэтгэмжийн мөнгийг олгохгүй хаасан тул гомдол гаргаж байна. Нийгмийн даатгалын байцаагчийн хариуцлагагүй буруутай үйл ажиллагаа байхад яагаад намайг буруутгаж байгаа юм бэ СХД-ийн нийгмийн даатгал. НДЕГ-аас иргэний буруутай үйл ажиллагаа биш байцаагчийн буруутай үйл ажиллагаа тул тэтгэмжийг зогсоохгүй өг гэсэн албан бичиг хийж өгсөн байхад дээд байгууллагын үүрэг даалгаврыг биелүүлэхгүй өөрсдийн дураар өөрсдийн буруутай үйл ажиллагааг хаацайлж тэтгэмж олгохгүй байгаа асуудалд арга хэмжээ авч шийдэж өгнө үү.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

- 09 сарын 11-нд БЗД-ийн 53-р сургууль дээр ус тасраад хүүхдүүдэд үдийн цай өгөөгүй байна. Цай хоол өгдөггүй юмаа гэхэд ундаа, жүүс өгч болох байсан. Ер нь байн байн ингэж хүүхдийн үдийн цайг тасалдаг. Дараагийн өдөр өмнөх өдрийн үдийн цайг нөхөж өгдөггүй. Энэ асуудлаар болон бусад шалтгаанаар захиралтай нь уулзах гэхэд "Захирал байхгүй" гээд уулзуулдаггүй. Захиралтайгаа уулзуулдаггүй учраас 11-11-д гомдол гаргаж байна. Ангийн багшид нь энэ асуудлыг хэлэхэд захирал нь багшийг нь загнаад байдаг юм. Холбогдох газарт нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.
- БЗД-ийн 183 дугаар сургууль шинээр ашиглалтад орсон юм. Манай хүүхдийн 2-6 бүлэг ангиараа шилжиж орсон бөгөөд н.Сэлэнгээ гээд багш дааж авсан. Энэ багш нь 4-р ангитай, одоо 2-р ангийг давхар авчихсан. Хүүхдүүдтэй ёс зүйгүй харилцаад хичээл хийх сурах сонирхолгүй болгоод байна. Эцэг эхчүүд санал хүсэлт гаргаад өөр багш авахыг санал болгоод өөр багш нар авахаар ирэхэд Сэлэнгээ багш нь элдэв ааш гаргаж ирсэн багш нарыг хөөгөөд өөрөө давхар анги авах гээд явахгүй байна. Сургуулийн удирдлага нь бид шийдэж хүчрэхгүй байна гээд шийдэхгүй байна. Бид Сэлэнгээ багшид хүүхдүүдээ өгмөөргүй байна, сурах ямар ч хүсэл эрмэлзэлгүй болгож байна, хүүхдүүдтэй ёс зүйгүй харилцаад байна. Тиймээс Боловсролын газраас энэ асуудлыг шийдэж өгнө үү.

НИЙТИЙН ЭРХ АШИГ ЗӨРЧИГДӨЖ БҮЙ

- Алтай хотхоны баруун талын хаалтыг буулгана гэсэн захирамж гарсан байна. Тус хаалтыг оршин суугчид буулгуулахгүй гэсэн байр суурьтай байна. Тус хаалт байхгүй бол манай хотхон дамжин өнгөрөх болж хувирдаг. Осол аваар ихээр гардаг. Хэрэв тус хаалтыг буулгасан тохиолдолд оршин суугчдын зүгээс баруун талын замаа хаахаа мэдэгдэж байна. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.
- БЗД-16, ХД 73-р байрны ард алга дарам газар дээр хүүхдийн тоглоомын талбай байгуулахаар ярилцаж тохироод хороондоо хандсан байсан. Гэтэл өнөө өглөө тус талбай дээр гэнэт барилга бариад эхэллээ. Хэн гэдэг этгээд ямар зөвшөөрлөөр тус барилгыг бариулж байгааг хянаж шалгуулмаар байна. Хүүхдийн эрх ашиг зөрчигдөж байна. Холбогдох байгууллагаар нь шалгуулж өгнө үү.

ХАЛУУН УС

- ХҮТ-2 гомдол гаргаж байна. БЗД-14, 48-12 тоотын оршин суугч байна. Манайх халуун усгүй 14 хоног болж байна. Манайд нийтийн засвар үйлчилгээ одоо хийгдээгүй байгаа. ХҮТ-2 дуудлага өгөөд ирэх үедээ гэрт орж ирж үзэхгүй. Насос асаалаа гэсэн мэдээлэл өгөөд явдаг. 7 хоног дуудлага өгөөд ирэхгүй байгаа нь бухимдалтай байна. Уламжлан шийдвэрлэж, иргэнд хариу өгнө үү.
- СХД-29, 21-р байрны халуун ус тасраад 50 хонож байна. Дулааны шугам засварлаад ийм байдал үүссэн гэсэн байгаа боловч шугамын ажил огт хийгдэхгүй байна. Энэ асуудлаар СХД-29 хорооны Засаг даргад хандсан боловч асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байна. Энэ асуудлыг шалган шийдвэрлэж өгнө үү.